

Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 22 дугаар зүйлийн 3 дугаар заалтыг үндэслэн
мэдээллийн нууцыг хадгална.

БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ОБЪЕКТЫН 20 ... ОНЫ -Р УЛИРЛЫН МЭДЭЭ

I. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА/ИРГЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

I.1. Гүйцэтгэгч ААНБ-ын мэдээлэл

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр											
Регистрийн дугаар											
Байршил	Нэр										Код
Аймаг, нийслэл											
Сум, дүүрэг											
Утас											
Гар утас											
Хариуцлагын хэлбэр											
Өмчийн хэлбэр											

I.2. Захиалагч ААНБ/иргэний мэдээлэл

Аж ахуйн нэгж, байгууллага/иргэний овог, нэр											
Регистрийн дугаар											
Байршил	Нэр										Код
Аймаг, нийслэл											
Сум, дүүрэг											
Утас											
Гар утас											
Хариуцлагын хэлбэр											
Өмчийн хэлбэр											

- Аж ахуйн нэгж, байгууллага 1, 4, 7, 10-р сарын 1-нд аймаг, нийслэл (дүүрэг)-ийн статистикийн хэлтэс, газарт;
- Аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтэс 1, 4, 7, 10-р сарын 4-ний дотор ҮСХ-нд цахимаар;
- Бусад шууд мэдээлдэг байгууллага 1, 4, 7, 10-р сарын 4-ний дотор ҮСХ-нд цахимаар мэдээлнэ.
- Асуулгын хуудасны I, II хэсгийг тухайн объектыг барьж эхлэх үед нэг удаа, аль

II. ОБЪЕКТЫН МЭДЭЭЛЭЛ

Байршил	МД	Нэр		Код
Аймаг, нийслэл	1			
Сум, дүүрэг	2			
Баг, хороо	3			
Объектын нэр (объектын нэрийг дэлгэрэнгүй бичнэ үү)	4			
Объектын дугаар	5			
Объектын төрөл	6			
Хүчин чадал	7	хэмжих нэгж	биет хэмжээ	
Давхрын тоо	8			
Барьж эхэлсэн огноо	9	_____ / ____ / ____ /он/сар/өдөр/		
Нийт талбай (м2)	10			
Төсөвт өртөг, (мян.төг) (Барилгын явцад төсөвт өртөг өөрчлөгдвөл 2-р баганад бичнэ)	11	анхны	өөрчлөгдсөн	

III. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ

мян.төг

Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл (өссөн дүнгээр)	Үүнээс:
		Улирлын дүн
А	1	2
Барилга угсралт, их засварын ажил		

IV. БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ОБЪЕКТЫГ АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН БАЙДАЛ

Барилга байгууламж, объектыг барьж дууссан огноо	_____ / ____ / ____ /он/сар/өдөр/
Улсын комисс хүлээж авсан огноо	_____ / ____ / ____ /он/сар/өдөр/
Барилгын нийт өртөг (мян.төг)	_____ / _____

Тамга Дарга /захирал, эзэн/ / /
Ерөнхий (ахлах) нягтлан бодогч / /

БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ОБЪЕКТЫН УЛИРЛЫН МЭДЭЭ (ББО-1)-НИЙ МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

I. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА/ИРГЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

- **ААНБ/иргэний нэр** - Тухайн аж ахуйн нэгж, байгууллага/иргэний оноосон нэрийг бичнэ. Хэрэв захиалагч нь иргэн бол тухайн иргэний овог, нэрийг бүтэн бичнэ.
- **Регистрийн дугаар** – Тухайн аж ахуйн нэгж, байгууллага/иргэнд УБЕГ-аас олгосон регистрийн дугаарыг бичнэ.
- **ААНБ/иргэний хаяг:** Аж ахуйн нэгж, байгууллага/иргэний харьяалагдах аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр, дугаар, холбоо барих утасны дугаарыг бичнэ.
- **Хариуцлагын хэлбэр:** Аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэрийн нэр, кодыг дараах ангиллын дагуу бичнэ. Захиалагч иргэний хувьд хариуцлагын хэлбэрийг бусад буюу 80 кодоор бичнэ.

Хариуцлагын хэлбэр
10=ХК, 11=ХХК, 20=ББН, 21=ЗБН, 30=Хоршоо, 40=ТӨҮГ, 41=ОНӨҮГ, 60=Төсөвт байгууллага, 70=ТББ, 71=Сан, 80=Бусад

- **Өмчийн хэлбэр:** Аж ахуйн нэгж, байгууллага/иргэний өмчийн хэлбэрийн нэр, кодыг дараах ангиллын дагуу бичнэ.

Өмчийн хэлбэр		
Төрийн	11=өмчийн,	12=өмчийн оролцоотой, 13=гадаадтай хамтарсан
Орон нутгийн	31=өмчийн,	32=өмчийн оролцоотой, 33=гадаадтай хамтарсан
Хувийн	21=Монгол Улсын,	22= гадаадтай хамтарсан, 23=гадаад улсын

II. ОБЪЕКТЫН МЭДЭЭЛЭЛ

Бие даасан барилга (орон сууц, үйлдвэрийн гол корпус, сургууль, цех агуулах) буюу байгууламж (зам, гүүр, далан, суваг, нүхэн гарц) түүнтэй холбогдож хийгдэх үндсэн ба туслах чанарын бусад байгууламж, гадна инженерийн бүх төрлийн шугам сүлжээ, хийц тоноглол, барилгын талбайд хийгдэх өндөржилт, тохижилтын бүх ажлыг **"ОБЪЕКТ"** гэнэ.

Янз бүрийн зориулалтаар шинээр буюу өргөтгөл, шинэчлэл хийх, нэгдсэн зураг төслөөр баригдах хэд хэдэн барилга байвал түүнийг **"БАРИЛГА БАЙГУУЛАМЖ"** гэнэ.

1-3-р мөр: Тухайн барилга байгууламж, объектын баригдаж байгаа аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр, кодыг бичнэ.

4-р мөр: Тухайн барилга байгууламж, объектын нэрийг дэлгэрэнгүй бичнэ. *Тухайлбал: Цагдаагийн гудамж Жоби үйлчилгээний төвийн зүүн талд, 64 айлын үйлчилгээний төвтэй орон сууцны барилга зэргээр байршил, хүчин чадлыг нь тодорхой бичнэ.*

5-р мөр: Тухайн барилга байгууламж, объектын дугаарыг аймаг, нийслэл, дүүргийн статистикийн хэлтэс, газрын барилгын салбар хариуцсан мэргэжилтэн бичнэ.

6-р мөр: Барилга байгууламж, объектын төрлийн нэрийг дэлгэрэнгүй бичиж, дараах холбогдох кодыг бичнэ.

Объектын төрөл	
Орон сууцны барилга	01 =Орон сууцны барилга, 02 =Орон сууцны барилга, үйлчилгээтэй, 03 =Орон сууцны барилга, гарааштай, 04 =Орон сууцны барилга, гарааш, үйлчилгээтэй
Орон сууцны бус барилга	11 =Үйлдвэрийн, 12 =Худалдаа, үйлчилгээний, 13 =Зочид буудал, 14 =Эмнэлэг, 15 =Сүм хийд, 16 =Цэцэрлэг, 17 =Сургууль, 18 =Соёлын, 19 =Спорт, биеийн тамир, 20 =Конторын, 21 =Орон сууцны бус бусад барилга (агуулах, гарааш, бусад)
Инженерийн байгууламж	31 =Эрчим хүчний, 32 =Холбооны, 33 =Төмөр зам, 34 =Хатуу хучилттай авто зам, 35 =Хайрган хучилттай авто зам, 36 =Сайжруулсан хөрсөн зам, 37 =Ердийн хөрсөн зам, 38 =Төмөр бетон гүүр, гүүрэн гарц, 39 =Модон гүүр, гүүрэн гарц, 40 =Далан, суваг, шугам, 41 =Бусад (бусад зам, талбайн ажил)
Их засвар	50 =Орон сууцны барилгын их засвар, 51 =Орон сууцны бус барилгын их засвар, 52 =Инженерийн барилга байгууламжийн их засвар

7-р мөр: Барилга байгууламж, объектын хүчин чадлын биет хэмжээг тоогоор, хэмжих нэгжийг дараах хүснэгтэд заасан нэгжээр бичнэ. Хэрэв тухайн барилга байгууламж, объектын хүчин чадлын хэмжих нэгж доорх хүснэгтэд ороогүй бол хэмжих нэгжийг дэлгэрэнгүй бичнэ.

Объектын төрөл	Хэмжих нэгж
Орон сууцны барилга	хаалга/айл
Үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, конторын барилга	м2
Зоогийн газар, сургууль, соёлын барилга	суудал
Эмнэлэг, зочид буудлын барилга	ор
Цэцэрлэгийн барилга	хүүхэд
Гарааш, авто зогсоол	машин
Эрчим хүчний байгууламж	кВт
Төмөр зам, гүүр, далан суваг	метр
Авто зам	км
Цахилгааны шугам, сүлжээ	кВт
Дулааны шугам, сүлжээ	метр

8-р мөр: Орон сууцны болон орон сууцны бус барилгын хувьд давхрын тоог бичих ба инженерийн байгууламжийн хувьд энэ мөр хамаарахгүй болно.

БАРИЛГЫН ДАВХАРТ газар дээрх бүх давхруудаас гадна давхрын хучилт нь газрын төвшнээс 2м-ээс дээш өндөрт байх техникийн, адрын хучилтын, хаяавчийн болон зоорийн давхар орж тооцогдоно.

9-р мөр: Тухайн барилга байгууламж, объектыг барьж эхэлсэн он, сар, өдрийг бичнэ.

10-р мөр: Барилгын нийт талбайг барилгын зураг төсөвт батлагдсан хэмжээ буюу м² (ханын дотор талын урт ба өргөний үржвэрийн нийлбэрээр)-аар бичнэ.

11-р мөр: Төсөвт өртгийг тухайн барилга байгууламж, объектын зураг төслийн баримт бичгийг үндэслэн тооцсон барилга байгууламж, объектыг барихад шаардагдах нийт мөнгөн хөрөнгийн нийлбэр дүнгээр бичнэ.

III. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ

1-р багана: Тайлант оны гүйцэтгэл: Тухайн онд барилга байгууламж, объектод зарцуулсан нийт зардлыг өссөн дүнгээр бичнэ.

2-р багана: Улирлын дүн: Тухайн улиралд барилга байгууламж, объектод зарцуулсан нийт зардлын дүнг бичнэ.

IV. БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ОБЪЕКТЫН АШИГЛАЛТАНД ОРСОН БАЙДАЛ

- **Барилга байгууламж, объектыг барьж дууссан огноо:** Тухайн барилга байгууламж, объектын барьж дууссан он, сар, өдрийг бичнэ.
- **Улсын комисс хүлээж авсан огноо:** Тухайн барилга байгууламж, объектыг ашиглалтанд оруулсан комиссын акт, дүгнэлтийг үндэслэн бүртгэлийн дугаар олгосон огноог бичнэ.
- **Барилгын нийт өртөг:** Тухайн барилга байгууламж, объектыг барьж эхэлснээс хойш ашиглалтанд оруулах хүртэлх хугацаанд барилга угсралт, их засварын ажилд зарцуулсан нийт зардлын дүнгээр бичнэ.